**Legal Assessment of Laws affecting media in Mongolia**

**Conducted for Media Ownership Monitor (MOM) Mongolia, November 2016**

## I. Хэвлэл мэдээллийн төвлөрөл болон өмчлөлийн холбогдолтой эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэлт, ил тод байдлын тухай

### I.1 Эрх зүйн орчин

*Хэвлэл мэдээллийн төвлөрлөөс урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.*

Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд хэвлэл мэдээллийн төвлөрөл, ноёрхлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах ямар нэгэн зохицуулалт байхгүй. 2010 онд баталж, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Өрсөлдөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "энэ хуулийн зорилт нь аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлахад... оршино[1]" гэсэн байдаг. Гэвч энэхүү хууль нь хэвлэл мэдээллийн салбар дахь төвлөрөл болон ноёрхлыг тусгайлан зохицуулдаггүй ба ийм зорилготой өөр хууль байхгүй. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2015 онд баталсан "Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага"[2]-ын тавдугаар зүйлд "Эзэмшлийн ил тод байдал"-ыг шаардсан ба 6.2-т "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлагаа бусдад шилжүүлэх, үндсэн үйл ажиллагаа, эрх үүргийг өөрчилсөн гэрээ байгуулахгүй", 11.12-д олон суваг дамжуулах үйлчилгээнд "Гадаадын аль нэг улсын телевизийн сувгийн тоо нь нийт гадаадын сувгийн 30 хувиас хэтрэхгүй байна" хэмээн заасныг эс тооцвол хэвлэл мэдээллийн салбарт эзэмшлийн төвлөрлийг хязгаарлах зохицуулалт үгүйлэгдсээр байна. Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн 1/. зах зээлд нийлүүлж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийн талаар хүчин чадалтай нь уялдуулан хянан зохицуулах, 2/. бодит зардлыг нь харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгох зохицуулалтыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) зохицуулалт хийхгүй.[3]

2016 оны 3 дугаар сард ХХЗХ-оос "Харилцаа холбооны салбарт зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн тогтоох аргачлал[4]"-ыг баталсан. Энэхүү аргачлалын дагуу Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарт[5] ажиллаж буй аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээг тодорхойлох; зах зээлийн газар зүйн хил хязгаарыг тогтоох, зах зээлд эзлэх

---

[1] Өрсөлдөөний тухай хууль, §1.1, http://legalinfo.mn/law/details/12?lawid=12
[2] Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага, 2-406-2.0 /2016.04.01/, ХХЗХ-ны 2015 оны 15 дугаар тогтоол /2016.04.01-ний өдрийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/
[3] Өрсөлдөөний тухай хуульд 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт өөрчлөлт
[4] *crc.gov.mn/contents//raw/3/7/425/20160307.doc*
[5] Хуучин нэрээр

хувийг тогтоох замаар тухайн зах зээлд давамгай байдалтай эсэхийг тогтоох аж. Энэхүү аргачлалын дагуу давамгай, эсвэл зүй ёсны монополь байдалтай нь тогтоогдвол Өрсөлдөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар тухайн байгууллага “бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт өргөдөл гаргана”. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж зөвшөөрсөн, эсхүл татгалзсан хариу өгнө. Хэрэв өргөдлийг хянаж өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэнэ гэж үзвэл татгалзсан дүгнэлтийг гаргана. Дээрх аргачлалын дагуу ХХЗХ-оос дараах байгууллагуудыг зүй ёсны монополь байдалтай хэмээн үнэлж, зарласан байна:

- Телевиз радиогийн олон сувгийн үйлчилгээг хиймэл дагуулаар дамжуулах үйлчилгээний зах зээлд ДДэш ТВ ХХК,
- Радио, телевизийн газрын дахин дамжуулах сүлжээ байгуулах, түүнийг ашиглах үйлчилгээний зах зээлд "Радио телевизийн үндэсний сүлжээ" УҮГазар,
- Кабелийн телевизийн үйлчилгээний зах зээлд Сансар Кабель ТВ,
- Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний зах зээлд Монгол шуудан ТӨХК,
- Интернетийн бөөний урсгал үйлчилгээниий зах зээлд “Жемнет” ХХК .[6]

“Тоон контентийн үйлчилгээний зохицуулалт, ерөнхий нөхцөл шаардлага”[7]-аар мобайл контент провайдер болон мэдээллийн вебсайтын үйлчилгээ эрхлэгчид Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх ёстой бөгөөд харин мобайл контент нийлүүлэгчид тусгай зөвшөөрөл авах ёстой.

Хэвлэл мэдээллийн төвлөрлийг тусгайлан зохицуулдаг хууль байхгүй хэдий ч, дээр дурьдсан хууль, журамд зах зээл дэх давамгай байдлыг тогтоох, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зарим зохицуулалтыг бий болгосон. Эдгээр нь гагцхүү өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд хамаарч буй бөгөөд, харин хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, төвлөрлийн асуудал огт зохицуулагдаагүй байна.

2014 онд УИХ-д өргөн барьсан “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль[8]”-ийн төсөлд редакцийн хараат бус байдлыг хангах, эзэд, хувьцаа эзэмшигч сэтгүүлзүйн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх, хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн эзэмшиж буй хувь хэмжээний талаарх өөрчлөлтийг олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэг хүлээх тухай заалт оруулсан. 2016 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн шинэ УИХ-ын 2016 оны 44 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хуралд өргөн

[6] Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага, 2-409-4. /2015.10.23/, ХХЗХ-ны 2011 оны 08 тоот тогтоол, /2014 оны 40, 2015 оны 60 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/ http://crc.gov.mn/k/1u/24
[7] http://www.crc.gov.mn/file/juram/content.pdf
[8] Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл. http://vip76.mn/law/project/294

мэдүүлсэн зарим хуулийн төслийг санаачлагч нь өөрчлөгдсөн, төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын санал, дүгнэлтийг авах шаардлагатай гэсэн үндэслэлээр санаачлагчид нь буцаасан байна. Тийнхүү буцаасан хуулийн төсөлд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль багтаж байгаа аж.[9]

*Хэвлэл мэдээллийн төвлөрлийн тухай албан ёсны тодорхойлолт байхгүй.*

Хэвлэл мэдээллийн төвлөрлийг тусгайлан зохицуулдаг хууль, журам байхгүй учир энэ салбар дахь төвлөрлийн тухай ямар нэгэн албан ёсны тодорхойлолт байхгүй. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх хэсэгт “зах зээлийн төвлөрөл“ гэж зах зээлд аж ахуй эрхлэгчийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдийн борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний эзлэх хувийг” хэлнэ гэж тодорхойлсон ба чухам хичнээн хувийг эзэлвэл “төвлөрөл” хэмээн үзэх талаар тодорхой заагаагүй. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн[10] 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт тухайн компанийн энгийн хувьцааных нь 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг; эсвэл ногдол ашиг, ашгийн хуваарилалтынх нь 20 буюу түүнээс дээш хувийг авах эрхтэй; эс бөгөөс аж ахуйн нэгжийн удирдлагын 20 буюу түүнээс дээш хувийг томилох эрхтэй, эсхүл үйл ажиллагааных нь бодлого чиглэлийг тодорхойлдог бол тухайн этгээдийг “харилцан хамааралтай этгээд” гэнэ хэмээн тодорхойлсон байна.

2012 онд баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилах сэргийлэх тухай хуульд[11] тухайн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг “хамаарал бүхий этгээд”; тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг “нэгдмэл сонирхолтой этгээд” хэмээн тодорхойлсон байдаг. Гэвч энэхүү хууль нь төсвийн санхүүжилт бүхий байгууллага, нийтийн албан тушаалтанд хамаарах учир хэвлэл мэдээллийн салбарт зөвхөн улсын төсвөөс санхүүждэг Олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал[12]-д хамаарах юм.

2011 онд Ерөнхийлөгчийн санаачлан өргөн барьсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг 2013 оны нэгдүгээр сард УИХ-аар хэлэлцэж байх үед “хууль санаачлагч нь хуулийн төслийн үзэл баримтлалаа бүхэлд нь өөрчлөнө” гэх үндэслэлээр буцаан татсан. Улмаар УИХ-ын 9 гишүүн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг төслийн өөр хувилбарыг санаачилж, 2014 онд УИХ-д өргөн барьсан боловч хэлэлцээгүй хойшлуулсаар 2016 оны УИХ-ын сонгууль тулсан билээ. Үүний зэрэгцээ Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг санаачилж, олон нийтийн дунд хоёр удаа хэлэлцүүлэг

[9] Зарим хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл буцаах тухай, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 44 дүгээр тогтоол

[10] http://www.legalinfo.mn/law/details/33?lawid=33

[11] Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилах сэргийлэх тухай хууль,, http://legalinfo.mn/law/details/397?lawid=397

[12] Авлигын эсрэг хууль, §4.1.4, www.legalinfo.mn/law/details/8928?lawid=8928

өрнүүлсэн боловч, одоог хүртэл УИХ-д өргөн бариагүй байна. Эдгээр хоёр хуулийн төсөл хэвлэл мэдээллийн ил тод байдлын талаар заалт орсон хэдий ч төвлөрлийн асуудлыг алинд нь ч хөндөөгүй юм.

*Хэвлэл мэдээллийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хянах гэж оролддог*

2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэгт хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт “Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд[13] эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна“ хэмээн заасан. Энэ хуульд “гадаадын хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/-ийг”[14] тодорхойлсноос үзэхэд төрийн бус этгээдээс дээрх зөвшөөрлийг шаардахгүй.

Энэхүү зохицуулалт нь хэвлэл мэдээллийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг хянах оролдлого мөн боловч, нэг талаар мэдээллийн хэрэгслийн зах зээлд эзлэх хувийг хэмжих арга, тогтолцоо байхгүй, нөгөө талаар гадаадын эзэмшлийн хувийг зөвхөн төрийн өмчит этгээдэд хамааруулсан учир төвлөрлийг үр дүнтэйгээр хянаж чадахгүй байна.

*Хэвлэл мэдээллийн төвлөрлийг зохицуулах тусгайлсан үүрэг бүхий ямар нэгэн байгууллага байхгүй.*

Өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, бүртгэх эрх мэдэл бүхий байгууллага бол ХХЗХ юм. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар ХХЗХ нь “өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй.”

ХХЗХ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хуулийн 4 дүгээр бүлэг, Радио долгионы тухай хуулийн 2 дугаар бүлгийн дагуу харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх болон радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгох, сунгах, хүчингүй болгох, бүртгэх, нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах, зохицуулалтын үйлчилгээний тариф тогтоох зэрэг асуудлыг хариуцдаг.

“ХХЗХ нь зөвшөөрөл олгохдоо мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний хөгжлийн ирээдүйн чиг хандлага, техник, технологийн дэвшил,

[13] Хөрөнгө оруулалтын тухай хууль, §3.1.11.“гадаадын төрийн өмчит хуулийн этгээд” гэж нийт гаргасан хувьцааных нь 50, түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийг;

[14] Хөрөнгө оруулалтын тухай хууль, §3.1.3

хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эрх ашигт нийцүүлэн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх зарчмыг баримтлана" /1.2/, "Зохицуулах хорооны дүрмийн 3.2.2 дугаар заалтыг үндэслэн энэхүү журмаар зохицуулж буй тусгай зөвшөөрөл олгох (нэмэлт, өөрчлөлт оруулах), түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх асуудлыг Зохицуулах хорооны хуралдаанаар, бусад (эзэмшигч өөрчлөгдөх, зөвшөөрлийн хугацааг сунгах) асуудлыг Хорооны даргын тушаалаар шийдвэрлэнэ" /1.3/[15] хэмээн заажээ.

ХХЗХ нь өөрийн вэб хуудаст тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчдийн нэр, хамрах хүрээ, тусгай зөвшөөрлийн хугацааг тусгай зөвшөөрлийн төрөл, ангилал болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хагас жил тутамд ирүүлдэг тайлан мэдээг нэгтгэн дүгнэж нийтлэх үүрэгтэй.

Харин энэ салбарт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журмын алинд ч хэвлэл мэдээллийн эзэмшлийг зохицуулах, төвлөрлийг бууруулах заалт байхгүй.

ШӨХТГ, болон Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Зар сурталчилгааны тухай хуулийн[16] хэрэгжилтэд хяналт тавих, хууль зөрчсөн тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх саналыг уг зөвшөөрлийг олгосон байгууллагаад (ХХЗХ-нд) гаргах эрхтэй. ШӨХТГ нь өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй. [17]

Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл шинээр нээх, худалдаж авахад тусгайлсан ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн[18] дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Тийнхүү бүртгүүлэх үйл явцад мэдээллийн хэрэгслийн эзэн, түүний зах зээлд эзлэх хувь, бизнесийн бусад төрөлд эзэмшиж буй хувь хэмжээ зэрэг нь хамааралгүй бөгөөд гагцхүү хэвлэл мэдээллийн үүсгэн байгуулагчийн дүрэм, мэдээллийн хэрэгсэл үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл, гүйцэтгэх удирдлага томилсон тухай тогтоол зэргийг зэргийг шаарддаг. Харин радио, телевизийн хувьд тусгай зөвшөөрөл авсан байхыг шаарддаг.

*Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий бүх байгууллага засгийн газарт харьяалагддаг.*

Радио долгионы тухай хуулийн 4 дүгээр зүйлд "Төр нь радио долгион өмчлөгчийн хувьд радио давтамж, радио давтамжийн зурвасыг ашиглах эрхийг

---

[15] Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам, 1 дүгээр зүйл
[16] Зар сурталчилгааны тухай хууль. http://legalinfo.mn/law/details/259?lawid=259
[17] Өрсөлдөөний тухай хууль, §14.1, http://www.legalinfo.mn/law/details/12?lawid=12
[18] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, §8.1.8, http://legalinfo.mn/law/details/10928?lawid=10928

бусад этгээдэд олгоно” гэж заасан. Тийнхүү төрийн өмнөөс радио долгион хуваарилах, өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд тусгай зөвшөөрөл олгох үүргийг ХХЗХ-нд олгосон. Энэхүү хорооны дарга, гишүүдийг ерөнхий сайдаас 6 жилийн хугацаагаар томилдог. Нэгэнт томилсон дарга, гишүүдийг ямар нөхцөлд хэн эгүүлэн татаж болохыг хуулиар тодорхойлоогүй. ХХЗХ-г Харилцаа холбооны тухай хуулийн дагуу байгуулсан бөгөөд уг хуульд Зохицуулах хорооны хараат бус байдлыг баталгаажуулсан ямар нэгэн заалт байхгүй. ХХЗХ-ны дарга, гишүүдийг томилох үйл явц олон нийтийн оролцоогүйгээр, ил тод бусаар явагддаг. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.2-дахь хэсэгт “Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй” хэмээн зааж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхийг оролдсон. Гэсэн хэдий ч тус байгууллагын дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх асуудал нь эрх барьж Засгийн газрын тэргүүнд байх тул томилгооны үйл явцыг тодорхой ашиг сонирхлоос бүрэн хамгаалж чадахгүй байна. Жишээлбэл, ХХЗХ-ны удирдлагын бүтцээс хамаарч эрх барьж буй намаас тусгай зөвшөөрөл олгох үйл явцад их нөлөөлдөг. Жишээлбэл, МАХН эрх барьж байсан үед энэ намд талтай сувгууд байгуулагдсан бол дараагийн дөрвөн жилд нь буюу 2004-2008 оны эвслийн засгийн газрын үед голчлон Ардчилсан намын байр суурийг дэмждэг зүтгэлтнүүд тусгай зөвшөөрөл авч, сувгаа нээсэн байдаг[19].

Харин ШӨХТГ нь Өрсөлдөөний тухай хуулийн 14.3-т заасанчлан “хуульд заасан үндсэн чиг үүргээ аливаа этгээдээс хараат бусаар, бие даан хэрэгжүүлнэ” гэсэн боловч уг байгууллагын үйл ажиллагааны дүрмийг Засгийн газраас баталдаг.

Дээр дурдсан бүх байгууллагын төсвийг Засгийн баталж, гүйцэтгэлийн хянадаг. Эдгээр байгууллагын санхүүгийн хувьд хараат бус байдлыг хангах ямар нэгэн хууль эрх зүйн зохицуулалт байхгүй.

**Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, цуцлах зохицуулалтад хэвлэл мэдээллийн төвлөрлийг харгалзаж үздэггүй**

Харилцаа холбооны тухай хуулийн дагуу ХХЗХ--ноос дараах тохиолдолд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах боломжтой:

- өргөдөл гаргагчийн хүссэн давтамжийн зурвас байхгүй /§14.2.1/;
- өргөдөл гаргагч нь харилцаа холбооны сүлжээг байгуулах, ашиглах, санхүү-эдийн засаг, техникийн болон мэргэжлийн боловсон хүчин, техникийн иж бүрдлээр хангагдаагүй /§14.2.2/;
- нийтийн эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэж үзсэн /§14.2.3/;.

ХХЗХ-оос өөрийн баталсан журмын дагуу өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн байгууллагад зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх, захиргааны хариуцлага хүлээлгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах, түдгэлзүүлэх,

[19] Азийн хэвлэл мэдээллийн барометр. Фридрих Эбертийн Сан. Улаанбаатар 2012 он. 48-р тал

тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох эрхтэй. Тийнхүү гаргасан захиргааны шийтгэлийн тухай шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн[20] 67 дугаар зүйлд заасны дагуу “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүртгүүлсэн тохиолдолд хүчинтэй.

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлп заасны дагуу шүүхэд гомдол гаргах боломжтой. Жишээ нь, 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Amjilt.com вэб сайтын сэтгүүлч гэрэл зураг бүхий баримтан дээр тулгуурлан “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гарчигтай нийтлэл бичсэн. Тус сайтыг хууль тогтоомж зөрчсөн үндэслэлээр ХХЗХ-ны хар жагсаалтад бүртгэн, Монгол Улсаас хандах хандалтыг хаасныг Захиргааны хэргийн 3 шатны шүүхээр шийдвэрлүүлж, 2015 оны 11 дүгээр сард хандалтыг сэргээлгэсэн байна.

Товчлон дүгнэвэл, тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, цуцлах зохицуулалтад хэвлэл мэдээллийн төвлөрлийг харгалзаж үздэггүй бөгөөд ийм шалтгаанаар тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдол байхгүй.

ХХЗХ нь “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 14-т заасны дагуу тусгай зөвшөөрөл олголтод хязгаар тогтоох боломжтой нь анхаарал татаж байна. Тийнхүү хязгаар тогтоохдоо дараах үндэслэлийг харгалзана:

- Тодорхой зах зээлд хэт олон үйлчлэгч өрсөлдөж, үр ашиггүй өрсөлдөөн үүссэн болохыг тогтоосон /14.1.1/
- Хөрөнгө оруулалт, түүний эргэн төлөгдөх хугацаа өндөртэй үйлчилгээг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалтын үр ашгийг хамгаалах зорилгоор /14.1.2/

Ийм нөхцлөөр хязгаарлалт тогтоох бол ХХЗХ-ноос үндэслэл, шалтгааныг тодорхойлж, хэлэлцүүлэг зохион байгуулах, тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

*Хэвлэл мэдээллийн эзэмшлийн төвлөрлийг хэмжих, тодруулах ямар нэгэн зохицуулалт, хэмжүүр, шалгуур байхгүй.*

ХХЗХ, ШӨХТГ, Улсын бүртгэл, оюуны өмчийн ерөнхий газар зэрэг нь бүгд төрийн байгууллагын хувьд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгох дүрэм, журам, шийдвэр, зөвшөөрөл олгосон этгээдийн жагсаалт зэргийг өөрийн санаачилгаар веб хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан нийтлэх үүрэгтэй. Тухайлбал, ХХЗХ-ны цахим хуудсанд тусгай зөвшөөрөл олгох нөхцөл, шаардлага, хурлын шийдвэр, дүрэм, журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, санхүүгийн тайлан зэргийг олж авах боломжтой.

ХХЗХ цахим хуудсан нийтлэгдсэн “Харилцаа холбооны зах зээлд зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох аргачлал”-ын ХХЗХ-ны цахим хуудсанд нийтлэгдсэн “Харилцаа холбооны зах зээлд зүй ёсны монополь болон

[20] Захиргааны ерөнхий хууль, http://www.legalinfo.mn/law/details/11259?lawid=11259

давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох аргачлал"-ын[21]" дагуу мэдээллийн технологи, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээ , зах зээлийн газар зүйн хил хязгаар болон зах зээлд эзлэх хувийг үнэлж, тухайн компани зүй ёсны монополь болон давамгай байдалтай эсэхийг тогтоодог. Энэхүү аргачлал нь хэвлэл мэдээллийн бизнесийн онцлогийг харгалздаггүй тул хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувь, сонины борлуулалтын хувь ширхэг, орлогын хэмжээ, эзэмшигчдийн хөрөнгийн хувь хэмжээ, бүтэц, эзэмшигчийн санал өгөх эрх зэрэг шалгуурыг ашигладаггүй. Түүнчлэн салбар доторх болон салбар хоорондын нэгдэх үйл явц, нэг болон хэд хэдэн этгээд үйлдвэрлэл, түгээлтийн үйл явцыг хянах эрх мэдэл, зар сурталчилгаа зэргийг бизнесийн төвлөрлийн чухал шалгуур хэмээн үзэхгүй байна.

Дээр дурдсан зохицуулалт, мониторингийн байгууллагууд нь Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэгт багтдаг учир Засгийн газраас үйл ажиллагаанд нь шууд нөлөөлөх боломжтой.

*Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн салбарт хөрөнгө оруулах, шинээр мэдээллийн хэрэгсэл бий болох, хэвлэл мэдээллийн нэг компани нөгөөхөө худалдан авах үйл явц тогтмол үргэлжилж буй.*

Тухайлбал 2011 онд байгуулагдсан Нэшнл Ньюс Корпорэйшн 2012 онд Блумберг ТВ Монгол, 2014 онд Засгийн газрын мэдээ өдөр тутмын сонинг нээсэн бөгөөд тус компанийн веб сайт дээр уг компанийн эзэмшилд мөн JCDecaux Mongolia багтдаг тухай дурьдсан байдаг. Блумберг ТВ Монгол нь нөгөө талаар Монголын хамгийн том банкуудын нэг болох Худалдаа хөгжлийн компанийн TDB Медиа ХХК-ны охин компани болохыг Блумбергийн цахим хуудсанд мэдээлжээ.[22]

2011 онд зөвхөн хөдөө орон нутагт 12 телевиз шинээр нээгдэж байсан бол 2012 -2015 онд орон нутгийн нийт мэдээллийн хэрэгслийн тоо 30 хувиар буурсан бөгөөд орон нутагт гарч буй 37 сонины тал хувь нь нэг компаний мэдэлд (Эгэл ХХК) хамаарч байна.[23] 2016 оны нэгдүгээр улирлын байдлаар дор хаяж найман хуулийн этгээд дөрөв ба түүнээс дээш тооны мэдээллийн хэрэгсэл эзэмшиж байна.

## I.3. Хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдлын зохицуулалт хангалттай биш.

УИХ-аас 2010 онд баталсан Монгол улсын аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.1.4-т "Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна"

---

[21] Харилцаа холбооны зах зээлд зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох аргачлал crc.gov.mn/contents//raw/3/7/425/20160307.doc

[22] http://www.bloomberg.com/research/stocks/private/snapshot.asp?privcapId=317061838

[23] Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Хэвлэлийн Хүрээлэн, 2016 он

хэмээн заасан. Энэхүү үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна. Одоогоор Үндэсний аюулгүй байдлыг зөвлөлөөс хэвлэл мэдээллий эзэмшил, харьяаллын ил тод байдлын талаарх заалтын хэрэгжилтийг хангах, хянах ямар нэгэн тогтоол, шийдвэр гаргаагүй байна.

Монгол Улсын Их хурлын 2012 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан[24] Монгол улсын засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил, орлогыг ил тод болгож, хэвлэлийн байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлж, иргэний хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах" тухай орсон. Үүний дагуу Хууль зүйн яамнаас 2016 он хүртэл боловсруулах хуулийн төслийн жагсаалтад "Хэвлэл мэдээллийн байгууллагын бүртгэл, түүнд тавих шаардлага, хувь, эзэмшил, орлого ил тод байх эрх зүйн зохицуулалт" бий болгох төлөвлөгөө орж, улмаар Хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Хууль зүйн яамны дэргэд байгуулсан ч тодорхой үр дүнг хүрээгүй. 2016 оны УИХ-ын сонгуульд олонхийн суудал авсан МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт "Хэвлэлийн эрх чөлөөг хуулиар хамгаалж, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хязгаарласан аливаа бодлого хэрэгжүүлэхгүй" /4.4.2/ байхаар амлаж байв. Гэсэн хэдий ч сонгуулийн дараа эмхлэн байгуулсан шинэ Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт[25] хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдлыг хангах тухай заалт ороогүй. Харин зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулах, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож "Шилэн тендер" шалгаруулалт" бодлого хэрэгжүүлэх тухай ерөнхий заалтууд оруулжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны "Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага"-ын[26] дагуу өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн "үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өргөн нэвтрүүлгийн хараат бус байдлыг хангах, нээлттэй, ёс зүйтэй байдлыг эрхэмлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн эзэмшлийг олон нийтэд ил тод байлгана". Уг журмын дагуу

- өргөн нэвтрүүлгийн байгууллагын эзэмшигчийн нэр,
- хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээг, (гадаад улсын хөрөнгө оруулалттай бол аль улсынх болохыг) мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын нэр, иргэншил зэргийг Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэнэ. Одоогийн байдлаар ХХЗХ-ны цахим хуудсанд 16 үндэсний хэмжээний өргөн нэвтрүүлэг, 25 Улаанбаатар хотын FM радио, орон нутгийн 73 телевиз, 56 кабелийн суваг дамжуулах үйлчилгээний зөвшөөрөл эзэмшигчдийн компани, үүсгэн байгуулагч болон захирлын нэрийг нийтэлсэн байна.

[24] http://zasag.mn/uploads/gov_plan2012-2016-1.pdf
[25] Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол

Эзэмшлийн хувийн талаарх мэдээллийг журмын дагуу нийтгэд ил болгоно гэсэн боловч цахим хуудсанд ийм мэдээлэл байхгүй. Харилцаа холбооны цахим хуудсанд иргэн бүр нэвтрэн орж, эдгээр мэдээллийг олж авах боломжтой боловч эзэмшлийн мэдээлэл нь иргэдэд зориулсан хуудсанд бус, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуудсанд байрлах бөгөөд хайж олоход тодорхой хүчин чармайлт шаардлагатай. Эзэмшлийн мэдээллийг хамгийн сүүлд 2016 оны нэгдүгээр сард шинэчилсэн бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид эзэд, хөрөнгө оруулагчдынхаа талаарх мэдээллийг жил бүрийн 1-р улиралд багтаан, өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлт орсноос хойш 1 сарын дотор Зохицуулах хороонд ирүүлэх үүрэгтэй.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, шаардлагыг биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх, захиргааны хариуцлага хүлээлгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авна. Гаргасан зөрчил болон зөрчлийг арилгуулахаар авсан шийдвэрийг Зохицуулах хороо тухай бүр холбогдох талууд болон олон нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй. Одоогоор эзэмшлийн ил тод байдлын тухай нөхцлийг хангаагүйн улмаас аль нэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй холбоотой ямар нэгэн хариуцлага тооцоогүй байна.

Цахим мэдээллийн хэрэгслийн хувьд мөн ХХЗХ-нд бүртгүүлэх ёстой боловч зөвхөн “Холбоо барих мэдээлэл, хэрэглэгчийн, санал хүсэлт, гомдлыг хүлээн авах төлөөлөгчийн газрын хаяг болон утасны дугаар зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах”-ыг шаарддаг.

Хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн ил тод байдлыг шаардсан ямар нэг хууль эрх зүйн болон сайн дурын зохицуулалт байхгүй. Эзэмшлийн мэдээллийг сайн дураар ил тод зарлах практик байхгүй, борлуулалт, зах зээлд эзлэх хувь хэмжээний талаарх мэдээллийг нууцалсаар байна.

2015 оныг хүртэл Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу аль нэг байгууллагын талаарх бүртгэлийн мэдээллийг авахын тулд тухайн байгууллагаас бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай байв.[27] Харин 2015 оны нэгдүгээр сард уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу хуулиар хориглосноос бусад улсын бүртгэлийн мэдээлэл хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын цахим хуудсанд нээлттэй байхаар болсон юм. Гэвч тодорхой байгууллагын талаар мэдээлэл авахын тулд уг байгууллагын бүртгэлийн дугаар шаардлагатайгаас гадна компанийн эздийн хувь хэмжээ, дүрэм гэх мэтийн дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудаснаас авах боломжгүй байна.

## I.4. Хэвлэл мэдээллийн байгууллагуудад төрөөс үзүүлж буй бусад нөлөөлөл

*Хэвлэл мэдээллийн олон ургальч байдлыг татварын бодлогоор дэмждэггүй боловч ялгаварлан гадуурхдаггүй.*

[27] Улсын бүртгэлийн ерөнхий хууль § 15.1

Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагуудад тусгайлсан ямар нэгэн онцгой татвар ногдуулдаггүй. Хэвлэл мэдээллийн байгууллагууд бусад аж ахуйн нэгжийн адилаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан[28] хувь хэмжээгээр татвар төлнө. Тодруулбал, жилийн гурван тэрбум хүртэлх төгрөгний албан татвар ногдуулах орлого олсон бол 10 хувиар, түүнээс дээш орлого олсон бол 300 сая төгрөг дээр гурван тэрбум төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна. Үүний зэрэгцээ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу байгууллагын орлого жилийн 50 сая төгрөгнөөс давахад 10 хувийн НӨАТ төлнө.

Орон нутгийн хэмжээнд гардаг жижиг сонинуудын эдийн засгийн чадавх болон орлого бага учраас ААНОАТ болон НӨАТ төлөх нь томоохон дарамт болдгийг “Ховдын мэдээ” сонины эрхлэгч, орон нутгийн хэвлэл мэдээллийн салбарт гуч гаруй жил ажиллаж буй сэтгүүлч А.Бямбасүрэн хэлж байна.[29] Тиймээс төрөөс орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад татварын хөнгөлөлт үзүүлбэл томоохон дэмжлэг болж чадахыг тэрбээр тэмдэглэсэн.

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.14-т “борлуулсан сонин”-г НӨАТ-аас чөлөөлөх тухай заасан байв. Энэ нь сонинуудын хувьд санхүүгийн таатай нөхцөл бүрдүүлж өгч байсан боловч 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр НӨАТ-ын тухай хуулийг шинэчлэн баталснаар дээрх хөнгөлөлт, чөлөөлөлт үгүй болжээ. Шинэ хууль 2016 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн учраас сонинууд эргээд НӨАТ төлдөг болсон.

*Шинээр бий болж буй хэвлэл мэдээллийн байгууллагад зах зээлд нэвтрэх босго, хаалт байхгүй.*

